



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2021 ОНЫ ГУРАВДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	4
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	10
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	11
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	12
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	14
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	14
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	15
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	15
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	16
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	16
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	17
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	17
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	17
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	18
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	18
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	19
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	19
ДОЛОО.ДҮГНЭЛТ	20

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021.11.17


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2021 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 225 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 ХЗХ буюу 9.3 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 43.6 хувь буюу 98 ХЗХ орон нутагт, 56.4 хувь буюу 127 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/




Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 10 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 9 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 2021 оны 3 дугаар улиралд 1 ХЗХ-нд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгон, 15 ХЗХ-ны сонгуульт гишүүд

болон гүйцэтгэх удирдлага, 4 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2017	2018	2019	2020	2021.III
ХЗХ-дын тоо	290	279	261	249	225
Шинээр олгосон	17 /1/	18	17	14	-
Хүчингүй болгосон	8	29	35	26	24
Түдгэлзүүлсэн	21	19	10	23	7
Сэргээсэн	4	7	1	6	-
ТЗ-ийн хугацаа сунгасан	54	100	52	49	81

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа




1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2021 оны 3 дугаар улирлын байдлаар 225 ХЗХ, 768 ажилтан, 75,771 гишүүн /75,580 иргэн, 191 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэгт 127 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 ХЗХ буюу 15.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 98 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд аймгуудад ХЗХ-д ихээр төвлөрсөн байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



График 2: “Гялс төгрөг” ХЗХ-ны салбарын тархалт

Тайлант улирлын байдлаар нийт 9 ХЗХ 64 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. Салбарын тоо өмнөх оны мөн үеэс 3 салбар буюу 4.9 хувиар нэмэгдсэн байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 5 ХЗХ-ны 57 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд “Гялс төгрөг” ХЗХ-ны 52 салбар Төв, Баян-Өлгий аймгаас бусад 19 аймагт тархалттай байна.



1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2021 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,588 гишүүн буюу 3.5 хувиар нэмэгдэж 75,771-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 191 хуулийн этгээд, 53.5 хувь буюу 40,515 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 58.8 хувь буюу 43,322 гишүүн Улаанбаатар хотод бүртгэлтэй бол 41.2 хувь буюу 30,397 гишүүн орон нутагт бүртгэлтэй байна.

График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/




Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо тогтмол өссөөр байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын нийт гишүүдийн 14.7 хувь буюу 6,586 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 64 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд байгуулагдсан 31 ХЗХ 10,673 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт 225 ХЗХ-ны 43.1 хувь буюу 97 ХЗХ 20-100 гишүүнтэй, 44.5 хувь буюу 100 ХЗХ 101-500 гишүүнтэй, 8.4 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 4.0 хувь буюу 9 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



- 20-100 гишүүнтэй
- 101-500 гишүүнтэй
- 501-1,000 гишүүнтэй
- 1,001-ээс дээш гишүүнтэй

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 9 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 47.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	97	5,722	7.6%
101-500 гишүүнтэй	100	20,718	27.3%
501-1,000 гишүүнтэй	19	13,030	17.2%
1,001-ээс дээш гишүүнтэй	9	36,301	47.9%
Нийт	225	75,771	100.0%

1.4 Бодлого, зохицуулалтын орчин

- Хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо /МХЗХҮХ/ хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, цаашид эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны талаар зөвлөмжийг цахимаар хүргүүлсэн.
- Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн мэдээллийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 43.3-т заасны дагуу хагас жил, жилийн эцсийн байдлаар Хороонд ирүүлэхээс гадна өөрчлөлт оруулах бүрд УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх нь нэг мэдээллийг төрийн хоёр байгууллагад бүртгүүлэх давхцалыг үүсгэдэг. Үүнийг цэгцлэхээр Хорооноос хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн мэдээллийг өөрийн цахим санд нэгтгэж, мэдээллийн баазыг үүсгэсэн бөгөөд дундын сан үүсгэхээр бэлтгэл хангаж байна.
- Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар холбоотой олон нийтээс санал авахаар журмын төслийг 2021 оны 7 дугаар сарын 23-ны өдөр цахим хуудсанд байршуулсан.
- Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд холбогдох саналыг хүргүүлсэн.
- Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4-т заасны дагуу 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 2021 оны 3 дугаар улирлын байдлаар нийт ХЗХ-дын 63.6% буюу 143 ХЗХ хэрэгжүүлсэн байна.
- Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэх ажлыг зохион байгуулж, тайлант улиралд нийт 225 ХЗХ-ны 49.3% буюу 111 ХЗХ гэрээ байгуулснаас 9 ХЗХ 2021 онд гэрээг шинэчлэн байгуулсан.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 19 ХЗХ 1,057 тохиолдлоор 241.7 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 1 ХЗХ 666 удаагийн тохиолдлоор 160.3 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 225 ХЗХ-оос 2021 оны 3 дугаар улирлын тайлангийн нэгтгэлд 17 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан.


2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 3: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-НЫ НИЙТ ГИШҮҮД		ҮҮНЭЭС:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	225	100.0%	127	56.4%	98	43.6%
Нийт гишүүдийн тоо	75,771	100.0%	44,842	59.2%	30,929	40.8%
Эрэгтэй	35,065	46.3%	19,304	55.1%	15,761	44.9%
Эмэгтэй	40,515	53.5%	25,411	62.7%	15,104	37.3%
Гишүүн хуулийн этгээд	191	0.2%	127	66.5%	64	33.5%
Гишүүдийн насжилт	75,580	100.0%	44,715	59.0%	30,865	40.8%
18-35 насны	23,267	30.8%	15,157	65.1%	8,110	34.9%
36-45 насны	21,901	29.0%	13,072	59.7%	8,829	40.3%
46-55 насны	17,806	23.5%	9,714	54.6%	8,092	45.4%
55-аас дээш	12,606	16.7%	6,772	53.7%	5,834	46.3%
Гишүүдийн боловсрол	75,580	100.0%	44,715	59.2%	30,865	40.8%
Дээд	31,799	42.1%	22,419	70.5%	9,380	29.5%
Тусгай дунд	12,317	16.3%	7,979	64.8%	4,338	35.2%
Бүрэн дунд	22,414	29.6%	12,949	57.8%	9,465	42.2%
Дунд	6,254	8.3%	1,166	18.6%	5,088	81.4%
Бага	2,796	3.7%	202	7.2%	2,594	92.8%
Нийт ажилтнуудын тоо	768	100.0%	479	62.4%	289	37.6%
Үүнээс: эмэгтэй	545	71.0%	354	65.0%	191	35.0%
Санхүүгийн програмтай	90	40.0%	44	19.6%	46	20.4%


ХЗХ-дын нийт гишүүдийн 59.8 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс залуу байна.

График 5: ХЗХ-ны гишүүдийн насжилт, УБ, орон нутгаар



Нийт гишүүдийн 42.1 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр байна.

График 6: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт зээлдэгч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	225	100.0%	127	56.4%	98	43.6%
Нийт зээлийн үлдэгдэл	208,065,387.21	100.0%	168,629,971.75	81.0%	39,435,415.47	19.0%
Нийт зээлдэгчийн тоо	35,763	100.0%	21,082	58.9%	14,681	41.1%
Иргэн	35,689	99.8%	21,019	99.7%	14,670	99.9%
Эмэгтэй	20,409	57.1%	12,406	58.8%	8,003	54.5%
Хуулийн этгээд	74	0.2%	63	0.3%	11	0.1%
Зээлдэгчдийн насжилт	35,689	100.0%	21,019	58.9%	14,670	41.1%
18-35 насны	12,860	36.0%	9,430	44.9%	3,430	23.4%
36-45 насны	10,993	30.8%	6,564	31.2%	4,429	30.2%
46-55 насны	7,718	21.6%	3,697	17.6%	4,021	27.4%
55-аас дээш	4,118	11.5%	1,328	6.3%	2,790	19.0%
Зээлдэгчдийн боловсрол	35,689	100.0%	21,019	58.9%	14,670	41.1%
Дээд	11,970	33.5%	7,333	34.9%	4,637	31.6%
Тусгай дунд	7,257	20.3%	4,783	22.8%	2,474	16.9%
Бүрэн дунд	10,825	30.3%	5,979	28.4%	4,846	33.0%
Дунд	4,902	13.7%	2,828	13.5%	2,074	14.1%
Бага	735	2.1%	96	0.5%	639	4.4%

Тайлант улиралд ХЗХ-д 35,763 зээлдэгчийн 208,065,387.21 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 56.4 хувь буюу 21,082 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 81.0 хувь буюу 168,629,971.75 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 43.6 хувь буюу 14,681 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 19.0 хувь буюу

39,435,415.47 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.8 хувь буюу 35,689 нь хувь хүн /үүний 57.1 хувь буюу 20,409 нь эмэгтэй/, 0.2 хувь буюу 74 нь хуулийн этгээд байна.

1 зээлдэгчид ногдох дундаж зээл 5,817.9 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	225	100.0%	127	56.4%	98	43.6%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	203,807,205.81	100.0%	171,882,716.24	84.3%	31,924,489.57	15.7%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	34,296	100.0%	17,853	52.1%	16,443	47.9%
Эмэгтэй	18,324	53.4%	9,416	52.7%	8,908	54.2%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	4,824,456.18	2.4%	3,871,005.75	2.3%	953,450.44	3.0%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	4,430	12.9%	3,491	19.6%	939	5.7%
Иргэн	4,413	12.9%	3,477	19.5%	936	5.7%
Эмэгтэй	2,678	7.8%	2,174	12.2%	504	3.1%
Хуулийн этгээд	17	0.0%	14	0.1%	3	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	198,982,749.63	97.6%	168,011,710.50	97.7%	30,971,039.14	97.0%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	29,866	87.1%	14,362	80.4%	15,504	94.3%
Эмэгтэй	29,800	86.9%	14,335	80.3%	15,465	94.1%
Иргэн	18,324	53.4%	9,416	52.7%	8,908	54.2%
Хуулийн этгээд	66	0.2%	27	0.2%	39	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	34,213	100.0%	17,812	100.0%	16,401	100.0%

18-35 насны	10,201	29.8%	5,779	32.4%	4,422	27.0%
36-45 насны	10,394	30.4%	5,506	30.9%	4,888	29.8%
46-55 насны	8,001	23.4%	3,976	22.3%	4,025	24.5%
55-аас дээш	5,617	16.4%	2,551	14.3%	3,066	18.7%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	34,213	100.0%	17,812	100.0%	16,401	100.0%
Дээд	15,356	44.9%	10,268	57.6%	5,088	31.0%
Тусгай дунд	5,102	14.9%	2,803	15.7%	2,299	14.0%
Бүрэн дунд	8,095	23.7%	3,346	18.8%	4,749	29.0%
Дунд	3,921	11.5%	942	5.3%	2,979	18.2%
Бага	1,739	5.1%	453	2.5%	1,286	7.8%

2021 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 34,296 хадгаламж эзэмшигчийн 203,807,205.81 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 56.4 хувь буюу 17,853 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 84.3 хувь буюу 171,882,716.24 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.9 хувь буюу 16,443 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 15.7

хувь буюу 31,924,489.57 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 2.4 хувийг хугацаагүй хадгаламжтай, 97.6 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 34,213 нь хувь хүн /үүний 53.4 хувь буюу 18,324 нь эмэгтэй/, 0.2 хувь буюу 83 нь хуулийн этгээд байна.

1 хадгаламж, эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,942.6 мянган төгрөг байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2021 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 289,371,682.20 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.5 хувь буюу 55,090,424.06 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.7 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 21.5 хувь буюу 36,885,268.94 мянган

төгрөг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 24.6 хувь буюу 40,172,573.51 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 6.3 хувь буюу 2,475,512.35 мянган төгрөг, нийт зарлага 8.7 хувь буюу 2,767,998.92 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 3.9 хувь буюу 292,486.58 мянган төгрөгөөр буурч 7,146,967.92 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны III улирал	2021 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	234,281,258.14	289,371,682.20		
Банкны зах зээлд эзлэх хувь	0.7%	0.7%	55,090,424.06	23.5%
Нийт зээл	171,180,118.27	208,065,387.21		
Банкны зах зээлд эзлэх хувь	1.0%	1.0%	36,885,268.94	21.5%
Нийт чанаргүй зээл	7,277,665.30	8,002,953.94		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.3%	3.8%	-0.6%	-14.1%
Банкны зах зээлд эзлэх хувь	0.4%	0.5%	0.0%	-
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	163,634,632.30	203,807,205.81		
Банкны зах зээлд эзлэх хувь	1.0%	1.1%	40,172,573.51	24.6%

Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18,283,275.63	25,675,069.91	7,391,794.28	40.4%
Нийт хоршоологчдын өмч	29,035,356.53	34,839,689.56	5,804,333.03	20.0%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	9,197,368.67	8,847,586.72	-349,781.95	-3.8%
Нийт орлого	39,307,035.21	41,782,547.56	2,475,512.35	6.3%
Нийт зарлага	31,867,580.72	34,635,579.64	2,767,998.92	8.7%
Цэвэр орлого, алдагдал	7,439,454.50	7,146,967.92	-292,486.58	-3.9%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 127 ХЗХ-ны нийт хөрөнгө 241,714,463.78 мянган төгрөг нь зах зээлийн 83.5 хувь, нийт зээл 168,629,971.75 мянган төгрөг нь зах зээлийн 81.0 хувь, нийт хадгаламж 171,882,716.24 мянган төгрөг нь зах зээлийн 84.3 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.7 хувь буюу 515,699.06 мянган төгрөгөөр нэмэгдэж 7,190,899.62 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 4.3 хувийг бүрдүүлж байна. Банк, ББСБ, төсөл

хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 2.3 хувь буюу 202,472.63 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 3.0 хувь буюу 955,637.3 мянган төгрөгөөр, нийт зарлага 4.9 хувь буюу 1,296,529.42 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 6.0 хувь буюу 340,892.12 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын 79 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны III улирал	2021 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	198,682,135.41	241,714,463.78	43,032,328.37	21.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	84.8%	83.5%	-0.01	-1.5%
Нийт зээл	141,873,990.73	168,629,971.75	26,755,981.02	18.9%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	82.9%	81.0%	-1.83%	-2.2%
Нийт чанаргүй зээл	6,675,200.56	7,190,899.62	515,699.06	7.7%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	91.7%	89.9%	-1.87%	-2.0%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.7%	4.3%	-0.44%	-9.4%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	141,020,194.33	171,882,716.24	30,862,521.91	21.9%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	86.2%	84.3%	-1.84%	-2.1%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	13,253,773.79	19,572,893.14	6,319,119.35	47.7%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	72.5%	76.2%	3.74%	5.2%
Нийт хоршоологчдын өмч	23,504,751.10	28,107,841.82	4,603,090.72	19.6%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	81.0%	80.7%	-0.27%	-0.3%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	8,960,282.17	8,757,809.54	-202,472.63	-2.3%
Нийт орлого	32,137,701.68	33,093,338.98	955,637.30	3.0%
Нийт зарлага	26,451,672.00	27,748,201.42	1,296,529.42	4.9%
Цэвэр орлого, алдагдал	5,686,029.68	5,345,137.56	-340,892.12	-6.0%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 98 ХЗХ-ны нийт хөрөнгө 47,657,218.42 мянган төгрөг нь зах зээлийн 16.5 хувь, нийт зээлийн үлдэгдэл 39,435,415.47 мянган төгрөг нь зах зээлийн 19.0 хувь, нийт

хадгаламж 953,450.44 мянган төгрөг нь зах зээлийн 0.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 21.2 хувь буюу 8,689,208.58 мянган төгрөг, нийт зарлага 27.2 хувь буюу 1,471,469.49 мянган

төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 2.8 хувь буюу 48,405.56 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,801,830.37 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн 32 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны III	2021 оны III	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	хувь
Нийт хөрөнгө	35,599,122.73	47,657,218.42	12,058,095.69	33.9%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	15.2%	16.5%	1.3%	8.4%
Нийт зээл	29,306,127.54	39,435,415.47	10,129,287.93	34.6%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	17.1%	19.0%	1.8%	10.7%
Нийт чанаргүй зээл	602,464.74	812,054.32	209,589.58	34.8%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	8.3%	10.1%	1.9%	22.6%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.1%	2.1%	0.0%	0.2%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	22,614,437.97	953,450.44	-21,660,987.53	-95.8%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	13.8%	0.5%	-13.4%	-96.6%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	5,029,501.84	6,102,176.77	1,072,674.93	21.3%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	27.5%	23.8%	-3.7%	-13.6%
Нийт хоршоологчдын өмч	5,530,605.43	6,731,847.74	1,201,242.31	21.7%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	19.0%	19.3%	0.3%	1.4%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	237,086.50	89,777.18	-147,309.32	-62.1%
Нийт орлого	7,169,333.53	8,689,208.58	1,519,875.05	21.2%
Нийт зарлага	5,415,908.72	6,887,378.21	1,471,469.49	27.2%
Цэвэр орлого, алдагдал	1,753,424.81	1,801,830.37	48,405.56	2.8%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР


3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2020 оны III улирал		2021 оны III улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	230,140,166.47	98.2%	277,950,090.21	96.1%	47,809,923.74	20.8%
Мөнгөн хөрөнгө	52,971,378.09	22.6%	63,776,794.65	22.0%	10,805,416.56	20.4%
Бэлэн мөнгө	6,194,473.88	2.6%	4,543,296.60	1.6%	-1,651,177.28	-26.7%
Банкинд байршуулсан харилцах	29,037,888.50	12.4%	21,129,197.45	7.3%	-7,908,691.05	-27.2%
Банкинд байршуулсан хадгаламж	17,739,015.71	7.6%	38,104,300.61	13.2%	20,365,284.90	114.8%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	100,000.00	0.0%	150,000.00	0.1%	50,000.00	50.0%
Арилжааны үнэт цаас	100,000.00	0.0%	150,000.00	0.1%	50,000.00	50.0%
Зээл /цэврээр/	166,264,967.94	71.0%	202,508,927.27	70.0%	36,243,959.33	21.8%
Нийт зээл	171,180,118.27	73.1%	208,065,387.21	71.9%	36,885,268.94	21.5%
Хэвийн зээл	159,055,152.16	67.9%	194,506,245.06	67.2%	35,451,092.90	22.3%
Хугацаа хэтэрсэн зээл	4,847,300.82	2.1%	5,556,188.21	1.9%	708,887.39	14.6%
Чанаргүй зээл	7,277,665.30	3.1%	8,002,953.94	2.8%	725,288.64	10.0%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,915,150.33	2.1%	5,556,459.95	1.9%	641,309.62	13.0%
Авлага	8,567,927.72	3.7%	9,786,291.97	3.4%	1,218,364.25	14.2%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	1,433,238.04	0.6%	970,876.91	0.3%	-462,361.13	-32.3%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	7,134,689.68	3.0%	8,815,415.06	3.0%	1,680,725.38	23.6%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,043,040.42	0.4%	1,040,305.03	0.4%	-2,735.39	-0.3%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1,192,852.30	0.5%	687,771.30	0.2%	-505,081.00	-42.3%
Өмчлөх бусад хөрөнгө	1,198,930.65	0.5%	694,985.76	0.2%	-503,944.89	-42.0%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	6,078.35	0.0%	7,214.46	0.0%	1,136.11	18.7%
Эргэлтийн бус хөрөнгө	4,141,091.67	1.8%	11,421,591.99	3.9%	7,280,500.32	175.8%

Үндсэн хөрөнгө /цэвэр/	3,914,112.94	1.7%	3,988,909.39	1.4%	74,796.45	1.9%
Үндсэн хөрөнгө	5,476,988.54	2.3%	5,897,232.39	2.0%	420,243.85	7.7%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,562,875.59	0.7%	1,908,323.00	0.7%	345,447.41	22.1%
Биет бус хөрөнгө	211,958.73	0.1%	7,417,196.47	2.6%	7,205,237.74	3399.4%
Биет бус хөрөнгө	298,542.58	0.1%	7,520,960.49	2.6%	7,222,417.91	2419.2%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	86,583.85	0.0%	103,764.02	0.0%	17,180.17	19.8%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.00	0.0%	15,486.13	0.0%	466.13	3.1%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.00	0.0%	15,486.13	0.0%	466.13	3.1%
Хөрөнгийн дүн	234,281,258.14	100.0%	289,371,682.20	100.0%	55,090,424.06	23.5%

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21.5 хувь буюу 36,885,268.94 мянган төгрөгөөр өсөж 208,065,387.21 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,556,459.95 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 202,508,927.27 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 хувь буюу 708,887.39 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.


ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2018-2021 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 189,619,513.88 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 65.5 хувийг, гишүүдийн тоо 24,656 байгаа нь нийт гишүүдийн 32.5 хувийг тус тус эзэлж байна.


2021 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 289,371,682.20 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.5 хувь буюу 55,090,424.06 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.1 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 22.0 хувийг, цэвэр зээл 70.0 хувийг тус тус эзэлж байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө			
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	189,619,513.88	65.5%	24,656	32.5%
2	1,000,000.0 -10,000,000.0	21	63,012,623.19	21.8%	20,523	27.1%
3	500,000.0-1,000,000.0	18	13,010,206.53	4.5%	7,668	10.1%
4	100,000.0-500,000.0	78	17,609,711.85	6.1%	14,707	19.4%
5	50,000.0-100,000.0	64	4,957,022.72	1.7%	5,734	7.6%
6	10,000.0-50,000.0	37	1,150,535.33	0.4%	2,421	3.2%
7	10,000.0 хүртэл	3	12,068.70	0.0%	62.00	0.1%
Нийт дүн		225	289,371,682.20	100.0%	75,771	100.0%



3.3 Зээлийн үйл

ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 208,065,387.21 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 71.9 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 202,508,927.27 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 70.0 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.3 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 20 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 84.4 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 6 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	20	175,672,359.61	84.4%
2	500,000.0-1,000,000.0	17	11,510,371.48	5.5%
3	100,000.0-500,000.0	67	14,939,411.99	7.2%
4	50,000.0-100,000.0	64	4,498,421.22	2.2%
5	10,000.0-50,000.0	46	1,411,430.85	0.7%
6	10,000.0 хүртэл	5	33,392.08	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	6	-	-
Нийт дүн		225	208,065,387.21	100%

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	35,763	100%	208,065,387.21	100%
Хэвийн	33,236	92.9%	194,506,245.06	93.5%
Хугацаа хэтэрсэн	1,246	3.5%	5,556,188.21	2.7%
Чанаргүй	1,281	3.6%	8,002,953.94	3.8%
<i>Хэвийн бус</i>	<i>438.00</i>	<i>34.2%</i>	<i>2,300,897.19</i>	<i>28.8%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>303.00</i>	<i>23.7%</i>	<i>2,229,417.49</i>	<i>27.9%</i>
<i>Муу</i>	<i>540.00</i>	<i>42.2%</i>	<i>3,472,639.26</i>	<i>43.4%</i>

2021 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.5 хувь буюу 194,506,245.06 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.7 хувь буюу 5,556,188.21 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.8 хувь буюу 8,002,953.94 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант


хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 13,559,142.15 мянган төгрөгийн үлдэгдэлд 41.0 хувь буюу 5,556,459.95 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.9 хувийг хэвийн, 3.5 хувийг хугацаа хэтэрсэн, 3.6

хувийг чанаргүй зээл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,281 зээлдэгчийн 8,002,953.94 мянган төгрөгийн үлдэгдлийн 28.8 хувийг хэвийн бус, 27.9

хувийг эргэлзээтэй, 43.4 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

График 8: Зээлийн чанар



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр өсөж 93.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.1 пунктээр буурч 2.7 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.5 пунктээр буурч 3.8 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 13: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5,072,856.16	9,823,871.64	8,016,247.57	6,880,480.23	3.3%
2	Уул уурхай, олборлолт	1,926,810.87	1,377,450.35	1,145,036.92	2,159,224.30	1.0%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,746,662.60	1,521,322.83	1,895,655.22	1,372,330.21	0.7%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	349,345.42	264,819.00	124,143.85	490,020.57	0.2%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	412,482.36	711,466.00	714,461.18	409,487.18	0.2%
6	Барилга	4,923,441.78	7,234,387.44	5,843,060.04	6,314,769.19	3.0%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	15,221,251.94	19,923,142.56	19,402,145.32	15,742,249.18	7.6%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	1,232,114.45	1,119,776.53	809,163.76	1,542,727.22	0.7%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,052,655.72	2,593,763.87	1,435,354.40	2,211,065.19	1.1%
10	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3,835,318.19	3,745,764.16	3,030,766.26	4,550,316.09	2.2%
11	Мэдээлэл холбоо	379,399.55	286,792.50	423,819.93	242,372.12	0.1%
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	4,369,542.55	29,330,570.66	18,711,183.61	14,988,929.60	7.2%
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2,419,174.55	1,617,718.39	2,247,102.87	1,789,790.07	0.9%
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	66,782.55	77,080.00	8,314.86	135,547.69	0.1%
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	324,595.65	111,569.00	182,339.22	253,825.43	0.1%
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.00	500.00	500.00	0.00	0.0%
17	Боловсрол	1,009,325.32	1,380,981.58	1,204,966.60	1,185,340.30	0.6%
18	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	951,329.41	939,954.79	845,098.61	1,046,185.59	0.5%
